


 БАТЛАВ
 ГОВИЙН БАГА ДАРХАН ЦААЗАТ
 ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
 ДАРГА..... Ч.БАТСҮХ
 2024 оны 04 дүгээр сарын 23

**ЦАГААН ХАДНЫ 04-Р ПОСТОНООС ГАШУУН СУХАЙТ БООМТ ХҮРТЛЭХ ХАР
 ЗАМ ДАГУУ ХОГИЙН ЦЭГИЙН ХАШАА ХИЙЖ СУУРИЛУУЛАХ АЖЛЫН
 ДААЛГАВАР**

АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛТ


1	Байршил	Байршил: Өмнөговь аймгийн Ханбогд сумын хайрхан баг Цагаан хаданд
2	Ажлын зорилго үндэслэл	Энэхүү хогийн савыг хийж байрлуулах зорилго нь нүүрс тээвэр, баяжмал тээвэрлэж байгаа жолооч болон тухайн замаар зорчиж байгаа тээврийн хэрэгсэл жолооч нараас гарах хогийг хогийн цэгт төвлөрүүлэх, байгальд шууд хаяхаас урьдчилан сэргийлэх эрүүл ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, дахин боловсруулах хог хаягдлыг үр дүнтэй ялгах нөхцөл боломжийг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд оршино.
3	Хийж дуусгах хугацаа	14 хоног
4	Хашааны үндсэн бүтэц	Үндсэн хийц бүтэц нь: Өргөн 2 м, өндөр 1.6 м, урт 2 м ,1м*1.2м хаалгатай, 2.1м*2.1м 10 см зузаан бетонон шалтай ,10см*10см нүхтэй сараалжин тортой 4 тал хашаанаас бүрдэнэ.
5	Хашааны зураг	Гурван талаас нь үзүүлсэн зурагтай
6	Техникийн	<p>Хогийн цэгийн хашаанд ашиглах материал, бүтээц тэдгээрийг хийж, угсарч суурилуулах ажилд дор дурьдсан шаардлага тавигдана.</p> <p>Нэг: Хашааны хажуу тал</p> <p>1.1 Хашаан нь 1.5м*2м хэмжээтэй рам нь 4см*4см 3мм зузаантай квадрат гагнаж, 3.5мм голчтой 10см*10см нүхтэй 2м*1.5м сараалжин тор тавьж гагнуураар бэхлэх, үндсэн хэсгээс доош 10 см хөлтэй. Хашааны рамыг хар саарал өнгөөр будах.</p> <p>Хоёр: Хашааны дээд тал</p> <p>2.1 3.5мм голчтой 10см*10см нүхтэй 2м*0.5м 2 ширхэг сараалжин торийг 1см*1см квадратаар эмжиж дөрвөн тал хашааны рамны дээд тал дээр тавьж гагнуураар бэхлэх.</p> <p>Гурав: Хашааны нүүрэн тал</p> <p>3.1 Хашаан нь 0.5м*1,6м хэмжээтэй рам нь 4см*4см 3мм зузаантай квадрат гагнаж, 3.5мм голчтой 10см*10см</p>

	тодорхойлт	<p>нүхтэй 0.5м*1.5м сараалжин тор тавьж гагнуураар бэхлэх,үндсэн хэсгээс доош 10 см хөлтэй. Хашааны рамыг хар саарал өнгөөр будах, дундаа 1м*1.2м хаалгатай байна.</p> <p>Дөрөв: Хашааны хаалга</p> <p>4.1 Хаалга нь 1м*1,2м хэмжээтэй рам нь 4см*4см 3мм зузаантай квадрат гагнаж, 3.5мм голчтой 10см*10см нүхтэй 1м*1.2м сараалжин тор тавьж гагнуураар бэхлэх хаалганы рамыг хар саарал өнгөөр будах, 2ш нугастай, дотон гадна бариултай,гадна түгжээтэй хийнэ.</p> <p>Тав: Хашааны шал</p> <p>5.1 Шал нь 4.4 кв 10 см зузаантай бетон хийх ба хашааны хөлийг суурь бетонд суулгах.</p> <p>Зургаа: Таних тэмдэгжүүлэлт</p> <p>6.1 Хашааны дээд ирэмгээс дээш 0.5м өндөртэй 40см*50см “ хогийн хаягдлын цэг” гэсэн бичигтэй самбар гагнуураар бэхэлж өгөх самбарын суурь цагаан өнгөтэй бичвэр нь улаан өнгөтэй байна.</p> <p>Долоо: Хогийн цэг суурилуулах</p> <p>7.1 Захиалагчийн заасан цэгт хогийн цэгийг суурилуулах.</p>
7	Техникийн нөхцөл,угсаралтын ажил	<ol style="list-style-type: none"> 1. Хогийн цэгийн хашааг зургийн дагуу хийж барилга угсралтын норм, стандартыг мөрдөж угсарна. 2. Хогийн цэгийн хашааг хийж,суурилуулж дуусч тухайн байгууллагын гишүүн болон холбогдох байгууллагуудын төлөөллийг байлцуулан шалгаж, акт үйлдэж тухайн тухайн байгуулгад хүлээлгэж өгнө. 3. Угсралтын ажлыг Монгол Улсад мөрдөж буй БНБД бусад норм, дүрэм, стандартын дагуу гүйцэтгэнэ 4. Газар шорооны ажил эхэлсний дараа ажлын талбайд хамгаалалтын хүрээ үүсгэж анхааруулах тэмдгийг бичгээр болон аюулгүй ажиллагааны тэмдэг, туузаар хийж явган зорчигчид зориулан хамгаалалтын түр гарц хийсэн байна. 5. Ажлын талбайд машин, механизм ажиллуулах үед орчны аюулгүй байдлыг хангах, ажлыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу хийсэн байна. 6. Байгалийн гамшигт үзэгдэл бороо, хүчтэй салхитай үед техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана.
8	Захиалагч байгууллага	Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа
9	Тоо хэмжээ	45 ширхэг хогийн цэгийн хашаа


БОЛОВСРУУЛСАН: НЯГТЛАН БОДОГЧ.....Н.БАТДЭЛГЭР

Хогийн цэгийн зураг


Хажуу тал



Нүүр тал



Дээд тал



Таних тэмдэг

- 4см*4см*3мм квадрат
- 10см*10см тор
- 1м*1,2м хаалга